

ХЭНТИЙ АЙМГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

1. Үндэсний нэгдсэл бахархалыг сэргээж, эх хэл, түүх, өв соёлоо дээдэлсэн эх оронч үзэл, эв нэгдлийг эрхэмлэсэн Монгол хүнийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ

2. Эрдэм мэдлэгтэй эрүүл чийрэг, нийгмийн идэвхитэй, хүнлэг, ёс туртахуунтай, дэлхийд үнэлэгдэх Монгол хүнийг төлөвшүүлж, гэр бүлд ээлтэй хүний хөгжлийн бодлогыг хэрэгжүүлнэ

3. Нийгмийн хамгааллын үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн, хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, өрхийн орлогыг нэмэгдүүлэн, хүн амыг орон сууцаар хангана.

4. Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангаж, ядуурал буурсан, хүнсний болон ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний дотоодын хэрэгцээг өөрсдөө хангадаг, экспортыг нэмэгдүүлсэн, хөрөнгө оруулалт, хуримтлалын чадавхаа дээшлүүлсэн аймаг болно.

5. “E Mongolia” төсөлд тулгуурлан иргэн, хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй хүргэсэн, төрийн албан хаагчийн мэдэлэг чадвар, сахилга хариуцлагыг сайжруулж, иргэн төвтэй төрийн үйлчилгээтэй аймаг болно.

6. Хүрээлэн байгаа орчны бохирдол доройтлыг бууруулах, байгалын баялгыг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгальд ээлтэй дэвшилтэт ногоон технологи нэвтрүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох бодлогыг хэрэгжүүлж, хүн амын эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангана.

7. Орон нутаг дахь батлан хамгаалах чадавхийг бэхжүүлж, хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам, иргэдийн амьдрах орчны аюулгүй байдлыг хангах, гамшгийн эрсдлийг бууруулах замаар хүн, нийгмийн аюулгүй байдлыг хангана.

8. Хүн амын нутагшилт, суурьшлын тогтвортой тогтолцоотой, байгалын унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалан хойч үедээ өвлүүлсэн, эдийн засгийн төрөлжилт, дагналт, хоршилт бүхий ногоон үйлдвэрлэл, үйлчилгээг, хөгжүүлж, өрсөлдөх чадвартай харьцангуй тэнцвэртэйгээр бүсийн тулгуур төвийн стандартаар хөгжүүлнэ.